

**Д.НАЦАГДОРЖ, Д.НАМДАГИЙН “БИ БИШ” ГЭХ ЖҮЖГИЙН ЗОХИОЛ
ДАХЬ ХУУРЧ СОНОМЫН ДҮРИЙН ҮЗҮҮЛСЭН ҮЙЛДЭЛ**

Цогт

Товч агуулга: Тус өгүүлэлд Д.Нацагдорж хийгээд Д.Намдаг хоёрын зохиосон “Би биш” хэмээх жүжгийн зохиол дахь хуурч Сономын дүрийн үзүүлсэн үйлдлийг түүний хуурдан дуулсан таван яруу найраг хийгээд зохиолын агуулга, утга сэдэв жич дүрүүдтэй холбон шинжилж, хуурч Соном нь тус жүжгийн зохиолын гол санааг илтгэсэн таван яруу найргийг хуурдан дуулж холбон уянгалах, бусад дүрүүдтэй харилцах, харгис гамингийн ял нүглийг шүүмжлэн, тэдний үхэл мөхлийг зүхэн, эх орноо хайрлан эх улсынхаа төлөө аливаа бүхнээ зориулах хайр сэтгэлгээг нэмэгдүүлэхэд бүр тун чухал үйлдэл үзүүлэв хэмээн шинжлэв.

Түлхүүр үг: Д.Нацагдорж, Д.Намдаг, “Би биш” жүжиг, хуурч Сономын дүрийн үзүүлсэн үйлдэл

Д.Нацагдорж (1906-1937) бол Монголын орчин үеийн уран зохиолын үндэслэгчийн нэг байсан. Тэрбээр шүлэг, найруулал, тууж, жүжиг зэрэг олон төрлөөр уран бүтээлээ туурвиж, өргөн олон уншигч түмэндээ бахархагдан шагшигдсаар ирсэн юм. Түүний бичсэн жүжгийн зохиол нь “Учиртай гурван толгой”, “Би биш”, “Монгол ардын суут”, “Нуугдсан эрдэнэ”, “Ондоо хүмүүжил”, “Их авгай” зэрэг зургаа олдож, түүний дотроос “Учиртай гурван толгой” хийгээд “Би биш” гэх жүжгийн зохиолд нь бүр хуурчийн дүр дүрслэгдсэн ба “Би биш” гэдэг жүжгийн зохиолд нь чухал дүрээр дүрслэгдэж, бүхий л жүжгийн үйл явдлыг хэлхэх, уянга шүлгийг шигтгэх, гол санааг довойлгоход бүрд нь чухал үйлдэл гаргажээ. Д.Нацагдоржийн жүжгийн зохиолоос “Учиртай гурван толгой”-г шүлгийн зохиолоос “Миний нутаг”-ийг судалсан эрдэмтэн олон байгаа боловч “Би биш” хэмээх жүжгийн зохиолыг судалсан эрдэмтэн их цөөн, нэн ялангуяа “Би биш” хэмээх жүжгийн зохиолыг түүний “Миний нутаг” хэмээх алдарт шүлэгтэй уялдуулан судалсан эрдэмтэн маш цөөн. Доор бид Д.Нацагдорж хийгээд Д.Намдагийн “Би биш” гэх жүжгийн зохиол дахь хуурч Сономын үзүүлсэн үйлдлийг голчлон шинжилж үзье. Д.Нацагдорж хийгээд Д.Намдагийн жүжгийн зохиол дахь хуурч гэдэг нь бидний одоогийн хэлдэг хуурчтай яг л адил ухагдахуунаар хэрэглэгдсэн биш. Бидний одоогийн хэлдэг хуурч гэдэг нь хуурын үлгэрийг нэлээд боловсронгуй ярьж чаддаг ардын урлагчныг зааж буй. Тэд бол үлгэр холбоо хэлэх, хуур хөгжимдөх, жүжиг жүжиглэх, дуу дуулахад бүр цагаарсан ардын урлагчин болох юм. Тэдний хэрэглэдэг хөгжим нь доор хөгийн дөрвөн утаст хуур байдаг. Гэтэл “Би биш” гэх жүжгийн зохиолд гарсан хуурч нь:

Нэгд, доор хөгийн дөрвөн утаст хуур татдаг биш, харин хялгасан хуур, даруй цуур буюу морин хуур тоглодог.

Хоёрт, хуурын үлгэр хэлдэг биш, зөвхөн дуу дуулж, ерөөл магтаал хэлж, хөгжим хөгжимдөж, жүжиглэн тоглодог ардын урлагчин болно. Тиймээс зохиогчоор жүжгийн зохиолдоо олонх байдалд “Хуурч” гэж хэлсэн боловч заримдаа хуурчийг бас “Хуурчин” хэмээн нэрлэсэн байдаг. Жишээлбэл “Би биш” гэдэг жүжгийн зохиолын хоёрдугаар үзэгдэлд “Хуурч хуурдан”, “Хуурчид архи өгнө” (*D.Naцагдорж-ийн бүрэн жокйал*, 2016:76) хэмээн хоёр удаа “Хуурч” хэмээн гарсан юм. Тиймээс тус жүжгийн зохиолд илэрсэн хуурчийг бидний өнөөдрийн ойлголтоор хуурын үлгэрийг нэлээд боловсронгуй хэлдэг ардын урлагчин хэмээн үзэж болохгүй. Гэвч тэр бол хуур хуурдаж, холбоо ба ерөөл магтаал хэлж, ардын дуу дуулдаг ардын урлагчин болох юм.

Нэг. “Би биш” гэх жүжгийн зохиолын тойм агуулга

“Би биш” гэх жүжгийн зохиол нийт таван үзэгдэлтэй, түүний үзэгдэл бүрийн агуулга нь доорх мэт.

Нэгдүгээр үзэгдэлд: Цэрэнжавын гэрт, Цэрэнжав (гэрийн эзэн, 50 гаруй настай), Ханд (Цэрэнжавын эхнэр), хуурч Соном (40 орчим настай), Чулуун (хүргэн хүү), Дэнсмаа (Цэрэнжавын охин) нар хуур хуурдан, дуу дуулан наргин цэнгэж байтал, гамингийн ноён, гамингийн дарга, гамингийн цэрэг үймэлдэн ирж энх тайван амьдралыг эвдэн Цэрэнжавын гэрийн арын байшинд хоноглохоор болов. Үүнд гамингийн ноён Цэрэнжавын гэрт бууж дайлуулахдаа Дэнсмаагийн цэвэрхэн өнгөнд ташааран халдсанд Чулуун, хуурч нар бүр дотор дотроо маш их ууртай баймуй. Гамингийн ноён бас хуурчаар хуурдан дуулуулж цэнгэлдүүлэх хэмээсэнд хуурч Сономоор гаминг эсрэгцсэн утга сэдэвтэй дуу зохион дуулахад, гамин ноён утга санааг нь ойлгохгүй тул дуулсан дууг сайн хэмээн сайшаана.

Хоёрдугаар үзэгдэлд: Орой үдэш Цэрэнжавын хойд байшинд гамин ноён, Дэнсмаа, хуурч гурав байж. Ноён, хуурч архи ууж сууна. Хуурч хуурдан, Дэнсмаа шанз цохин “Цагаан сар”, “Жижөү хот”, “Өндөр диянь” зэрэг дууг дуулан, ноён Дэнсмааг өвөр дээрээ суулган үнсэх зэргээр аашлан байгаад удалгүй өөрөө салгалан өнхөрч унахад, Дэнсмаа гарч одно. Энэ үед хуурч гаминг хараасан дууг найман бадаг зохион дуулж, өөрийн хорслоо тайлна. Ноён сэрээд хуурчаас Дэнсмааг дахин давтан асуухад, Дэнсмаа гаднаас орж ирээд миний ахыг танай цэрэг барьж авсан хэмээн уйлахад, ноён Чулууныг тавиулж, Чулуунтай ах дүү болсон хэмээн өөрийн буугаа Чулуунд өгнө. Чулуун тэр буугаар ноёныг буудах гэхэд Дэнсмаа, хуурч хоёул хориглоно.

Гуравдугаар үзэгдэлд: Шөнө Цэрэнжавын гэрт Цэрэнжав, Ханд, хуурч, Дэнсмаа нар хамтаар байх бөгөөд Чулуун цэрэгт явахыг бэлтгэж байна. Хойд байшинд гамин хятадаар хуруу жимэлцэж¹ наргиж буй. Энэ үед нэг цэрэг ирээд Дэнсмаа хийгээд хуурчийг хойд байшинд дуудаж байна хэмээхэд, Дэнсмаа багахан байгаад очъё гэнэ. Энэ завсар Дэнсмаа хийгээд Чулуун үнсэлцэн салалцаад, Дэнсмаа хойд байшинд орж найр үүсгэн өндөр дуугаар дуулна. Чулуун энэхүү найрын завшааныг ашиглан нэгэн харуулын цэргийг буудаж алаад цэрэгт орохоор зугтаан явав. Ноён Дэнсмааг байшинд хорин цэргээр сахиулж, өөрөө архи ууж согтоод орон дээр унаж ухаан алдав. Дэнсмаа аргагүй болж уйтгарлан, цонхоор шинэ сарыг үзэн санаа алдан суухад, хуурч хуураа хөглөн янагийн дуу дуулан хөгжимдсөнд, Дэнсмаагийн янаг хонгороо санах сэтгэл нь нэн хүндэрнэ.

Дөрөвдүгээр үзэгдэлд: Хойд байшинд гамингийн ноён, дарга хоёр маш их ууртайгаар Дэнсмаа хийгээд хуурч хоёроос Чулуун хаашаа явсан, манааны цэргийг хэн алсныг шүүн асуухад бүр “мэдэхгүй” хэмээнэ. Үүнд ноён уурлаж, Дэнсмааг модоор цохиход Дэнсмаа нүүр рүү нь нулимна. Ноён Дэнсмаагийн нэг гэрийн хүмүүнийг алах хэмээж цэрэгт тушаагаад, ширээ засан архи зууш бэлтгэн хятад дууч ба хятад хуурчийг авчруулан найр үүсгэнэ. Гамингийн ноён, дарга, дууч бүгдээр архи ууж согтоод байсан үед, цэрэг орж ирээд монгол

¹ Хуруу жимэлцэх - Хятадын хуруудан тоглохыг хэлнэ.

цэрэг ирснийг мэдүүлсэнд тэд тоосонгүй, энэ үед дарга нь суманд оногдон үхэхэд дууч, хуурч (хятад) нь зугтан явж, гагц ноён л чичрэн дагжиж үлдэнэ.

Тавдугаар үзэгдэлд: Гадна буун дуу үргэлжилнэ, хойд байшингаас ноён зугтан гарч ирээд Цэрэнжавын гэрт орон ширээн доор нуугдана. Хуурч гэрт орж ноёныг ширээний доороос татан гаргаад Цэрэнжав, Ханд, Дэнсмаа нарын хамт түүний сахлыг зулгааж, эмэгтэйн үс ба дээл өмсгөөд шуудайнд хийж дээр нь сандайлан суугаад ноёны ял гэмийг тоочин Дэнсмааг зовоосон учрыг нэгд нэгээр тоочин дуулна. Энэ үед Чулуун амар түвшнээр буцан ирсэнд бүгдээр баярлалцан амар амгалангаа мэдэлцэн, Ханд, Дэнсмаа цай идээ бэлтгэн яарна. Үүний дараа, бүгдээр цай идээ зооглон өнгөрснөө ярилцах зуур, хуурч Хандын саналаар, муу цаг өнгөрч, сайн цаг хүрч ирж байгаад хуураа хөглөн сайхан ерөөл, нэгэн дуугаа дуулж олон бүгдийн дур бахыг булаана. Энэ үед Чулуун гэнэт Дэнсмаагаас өнөөх ноёныг асуусанд Дэнсмаа шуудайтай юмыг зааж “мэдэхгүй” гэнэ. Цэрэнжав, хуурч, Ханд нар мөн нэгэн зэргээр “мэдэхгүй” гэнэ. Чулуун, ноёныг шуудайнаас гаргаад, “ноён мөн уу?” хэмээсэнд ноён “би биш” хэмээнэ. Чулуун буугаа гаргаад нүүр лүү нь зангахад, ноён ихэд айж мөн л “би биш, би биш, би биш” хэмээж жүжиг өндөрлөнө.

Хоёр. “Би биш” гэх жүжгийн зохиол дахь хуурч Сономын дүрийн үзүүлсэн үйлдэл

Д.Нацагдорж хийгээд Д.Намдагийн жүжгийн зохиол “Би биш”-д хуурч нь хамгийн чухал нэгэн дүрээр дүрслэгдсэн юм. Үүнийг зохиогч гуай хуурч Сономыг зохиолын дүрийн хамгийн өмнө нь жагсааснаас ч тодорхой мэдэж болно. Дээр танилцуулсан мэтээр тус жүжигт нийт таван шүлэглэл буюу дуу найруулагдан орж, түүнийг бүгдийг хуурч Соном хуурдан дуулсан юм.

Нэгдүгээр үзэгдэлд: Хуурч Сономоос гамин хийгээд Монголын газар нутгаа худалдагсдыг гамин ноёны өмнө найман бадаг дуугаар зүхэн хараажээ. Түүний нэгээс дөрөвдүгээр бадагт гамингийн цэрэг Монгол нутагт түрэмгийлэн ирээд ард иргэдийг үймүүлж байгаа байдлыг дүрслэн үзүүлжээ. Жишээлбэл:

“Хялгасан хуураа хуурдъя даа хэмээсэн юм

Гамингийн цэргүүд гүйлдээд байна уу даа.

Хангинатал, хангинатал дуулъя даа хэмээсэн юм

Хаалга үүдээр хөлсөөд байна уу даа.

Эртний дууг эгшиглэе дээ хэмээсэн юм

Илжгэн гамингууд үймүүлээд байна уу даа.

Энэхэн Монголын оронд нь бол

Энхээр амьдран суусан юм сан” (D.Naᠰaᠭᠳorji-yin büren jokiyaᠯ, 2016:74)

гэж харгис гамин энх амгалан байсан Монгол нутагт түрэмгийлэн ирээд ардын амьдралыг түйвээж байгаа байдлыг зураглан үзүүлжээ. Түүний дараа нь хуурчаас:

“Холын газраас ховдоглон ирсэн гахайнууд

Хомхой шүлсээ хойгуур, урдуур цувруулна

Үнсэнхэн царйлан ирсэн өмхий цагаан чөтгөрүүд

Үмхэх залгихыг эрж үүгээр түүгээр тэнүүчилнэ” (D.Naᠰaᠭᠳorji-yin büren jokiyaᠯ, 2016:74)

хэмээн харгис гаминг “ховдог гахай”, “өмхий чөтгөр” гэж хараасан байна. Дараагийн хоёр бадагт:

“Халхынхаа сайхан нутагт болбол,

Хуур дуугаа наадсаар ирснээ

Хангинанхан ярууд нь хүмүүн бүхэн баясдаг

Хааяа аяархан болохуйд нь хамаг бүхэн уярах нь юун билээ

Адуу л унага минь янцгаан унгалдаад

Айраг цагаа минь дүүрэн мэлмэлзэх үед

Уудамхан ч талдаа уужмаар давхиж

Уртын л дуугаа хангинатал дуулдаг билээ” (D.Naᠰaᠭᠭᠳᠣᠷᠵᠢ-yin бүрэн jokiyaᠯ, 2016:75)

гэж харгис гамин ирэхээс өмнөх Монгол нутгийн энх түвшин, амар амгалан, баяр жаргалт амьдралыг эргэцүүлэн дуулж, түүний дараа нь газар нутгаа худалдсан зальхайчуудыг:

“Шар л хүрэмтнүүд хар л магнагтнууд

Шашны л дайсан, төрийн л хулгайчууд

Сайхан газрыг минь шунахайчуудад худалдаад

Саруул нутгийг минь бузар хүмүүсээр дүүргэв” (D.Naᠰaᠭᠭᠳᠣᠷᠵᠢ-yin бүрэн jokiyaᠯ, 2016:75)

хэмээн нэгд нэгээр дурдан шүүмжлэв. Хамгийн сүүлийн бадагт:

“Тунгалаг сайхан тэнгэртэй төрсөн миний нутаг аа

Түмэн эхээ дуулан түрж найрлан хөгжилддөгийг

Мойног хуруу мөгүс гэж, морин хуур дүнхийхүйд

Монгол ах дүү та нарын сэтгэл хөдөлнө” (D.Naᠰaᠭᠭᠳᠣᠷᠵᠢ-yin бүрэн jokiyaᠯ, 2016:75)

гэж монгол ах дүү нараа гаминг цохих эсрэгцэл тэмцэлд уриалан дуудсан юм.

Хоёрдугаар үзэгдэлд: Хуурч Сономоос гамин ноёны Дэнсмаа хүүхнийг зовоож Монгол орныг цөлбөж байгаа байдлыг найман бадаг ёжлон дуулсан юм. Хуурч эхэлмэгцээ:

“Харийн газраас ирсэн

Хамуутай зэвхий нохойнууд

Халхын хүүхнийг үнэртэж

Хамар амаа долоомуй чи

Үнсэн өнгөтэй чөтгөрүүд

Өлөгчин саарал гийчингүйд

Өлссөн гэдсээ хооллож

Өвчүү цээжээ маажилмуй чи” (D.Naᠰaᠭᠭᠳᠣᠷᠵᠢ-yin бүрэн jokiyaᠯ, 2016:76-77)

гэж эхний бадагт халхын хүүхнийг зовоож байгаа байдлыг, хоёрдугаар бадагт Монгол орныг цөлбөж байгаа байдлыг тус тус үнэн бодтойгоор дүрслэн дуулжээ. Дараагийн хэдэн бадагт мөн дээрх бадагтай адилаар харгис гамингийн ял хилэнцийг нэгд нэгээр дурдан бадаг давталтын аргаар утга санаагаа лавшруулан дайран шүүмжлэв. Түүнд:

“Орон байшин бэдэрсээр

Орж ирсэн тэнэмлүүд

Өнгөтэй хүүхнийг үзээд

Өлөн шүлсээ гоожуулмуй чи

Харангассан гэдсээ цэдийлгэж

Хар архиар халууцуулмуй чи

Харгис толгойгоо мансууруулж

Хараалгаж зүхэхдээ таарав уу чи” (D.Naᠰaᠭᠭᠳᠣᠷᠵᠢ-yin бүрэн jokiyaᠯ, 2016:77)

хэмээн харгис гамингийн ял нүглийг дурдан шүүмжилж, хамгийн сүүлд нь тэдний үхэл мөхлийг:

“Өлссөн гэдсээ шандууруулаад
Өвөр дээрээ бөөлжмүй чи
Өнгөлзсөн санаа чинь үүтгээд
Үнсэн царай чинь зэвхийрнэ
Хувхай толгой чинь угзайгаад
Хоймор сууж чадах үгүй ээ чи
Хоёр гараа хугасхийгээд
Хог дээр хэвтвээс таарна” (D.Naṣaygdorji-yin büren jokiyaḷ, 2016:78)

гэж зүхэн хараасан байна.

Гуравдугаар үзэгдэлд: Хуурчаас Дэнсмаагийн янаг хонгор Чулуунаа санаж байх хайр сэтгэлийг түүний шинэ сарыг харан гөлөрч байгаа үед уянгалан дуулжээ. Тус дуу нийт найман бадаг, түүн дэх долоон бадаг нь “Төгрөг сайхан саран минь”, “Гайхамшигт сайхан саран минь”, “Ялгуун сайхан саран минь”, “Тэргэл сайхан саран минь”, “Тунгалаг сайхан саран минь”, “Мөнгөн аяга шиг саран минь”, “Алман сайхан саран минь” хэмээх мөрөөр эхлүүлсэн нь маш сонирхолтой сайхан болсон байна. Хуурч Сономоос урьдаар:

“Төгрөг сайхан саран минь
Тэртээ уул дээгүүр цухуйна
Зурайн гарч ирэхдээ
Миний зүрхийг эсгэнэ
Гайхамшигт сайхан саран минь
Хайрын ертөнцөөс туяарна
Хасын сайхан гэрэлд чинь
Хайртай амраг минь харагдах шиг” (D.Naṣaygdorji-yin büren jokiyaḷ, 2016:83)

гэж саран мандахад хайрт амрагаа санаж байгаа хайр сэтгэлгээг уянгалан дуулжээ. Дараагийн бадгуудад мөн адил утга санааг лавшруулан гаргасан байна. Жишээлбэл хамгийн сүүлчийн хоёр бадагт:

“Мөнгөн аяга шиг саран минь
Мөсөн болрын туяатай
Мөнхийн амраг хүүтэйгээ
Мөд уулзахыг мөрөөдөнө
Алман сайхан саран минь
Арван зүгтээ цацарна
Агуу сайхан гэрэлд чинь
Амрагтайгаа явах сан” (D.Naṣaygdorji-yin büren jokiyaḷ, 2016:84)

хэмээн янаг хоёрын нэг нэгнээ санан мөрөөдсөн гүн гүнзгий хайр сэтгэлгээг төгрөг сарны гэрэлтэй холбон хуурдан дуулжээ. Энэ нь хэлэлгээнгүйгаминг устгахаар цэрэгт явсан Чулуунаа санан мөрөөдөж байгаа Дэнсмаагийн сэтгэл зүрхийг улам илүү игтлэн уяруулах нь лавтай.

Дөрөв, тавдугаар үзэгдэлд: Дөрөвдүгээр үзэгдэлд хуурч соном дуулан шүлэглэсэн зүйл байхгүй харин тавдугаар үзэгдэлд дөрөв, тавдугаар дууг дуулсан байна. Хуурч дөрөвдүгээр дуугаа гамингийн ноёныг шуудайнд хийж уяад түүний дээр сандайлан сууж байгаад дуулсан юм. Тус дуу нь мөн найман бадаг байж, үндсэн санаа нь гамингийн цэрэг ноёныг зүхэн харааж, ял гэмийг нь тоочиж, үхэл мөхлийг нь зөгнөжээ. Тус дуу нь утга санааны хувьд нэг, хоёрдугаар дуутай маш ойролцоо боловч хэл хэллэгийн хувьд нэн хурц ширүүн, дайчин чанартай болжээ. Жишээлбэл:

“Сэлмээ чирсэн яргачин чи
Сүмэлзэн сүмэлзэн ирсэн чи
Сүүл соёогоо нуусан нохойнуудыг
Солгой хуурч би зүхнэ дээ
Өнгөтэй юмыг үзмэгц
Нүдээ бүлтийлгэсэн ховдгууд
Үзэсгэлэнтэй хүүхнийг хармагц
Шүлсээ гоожуулсан ужидууд аа” (D.Naцагdorji-yin büren jokiya, 2016:90)

гэж дуулан эхлүүлээд харгис гамин ноёны ял гэгийг Дэнсмаа хүүхэнд санааширсан, Дэнсмаа хүүхнийг зовоосон зэрэг үйл явдлаар бодтой тоочиж, гамингийн ноён хийгээд түүний цэргийн үхэл мөхлийг утга лавшруулан дахинтай зургаан бадаг дуугаар зүхэн хараасан юм. Түүний хамгийн сүүлийн хоёр бадагт:

“Сүрхий ирсэн гамин ноёны
Сүлд нь зайлаад хэвтэнэ үү чи
Сүүдрийг нь дагасан муусайн цэргүүд
Сүнс нь гараад зугтана
Сонирхоод ирсэн гамин ноёныг
Сумтай бууны аманд
Шунахай хувхай толгой чинь
Чулуун хүүгийн илдэнд ээ” (D.Naцагdorji-yin büren jokiya, 2016:91)

гэж гамин ноёны айн хэлмэгдэж байгаа шившигт дүр байдал ба Чулуун хүүгийн буу сум, илд зэвсгээр амийг нь хороож өшөөгөө тайлах гэж байгаа байдлыг дуулан шүлэглэжээ. Хуурчийн дуулсан тавдугаар дуу буюу ерөөл бол Д.Нацагдоржийн алдарт яруу найраг, Монгол түмний зүрх сэтгэлд мөнхөрсөн “Миний нутаг” шүлэг болох юм. Тус яруу найргийн “Би биш” гэх жүжгийн зохиолд найруулагдан орсон нь тус жүжгийн зохиолын урлагийн үнэ цэнийг улам нэг өндөр хэмжээнд хүргэж, Монголчуудын эх нутаг буюу улс орноо хайрлах хайр сэтгэлгээг оргилуулж, эх орныхоо төлөө өөрийн аливаа бүхнээ зориулах зориг санааг эрчлүүлж чадсан байна. Тус яруу найраг нийт арван хоёр бадаг байж, өмнө нь хэвлэгдсэн “Миний нутаг” шүлгийн бусад хувилбараас төдий их ялгаа зөрөө байхгүй, зөвхөн хэдхэн газарт нь үг үсгийн зөрүү хийгээд мөрийн солигдол харагдана. Тус яруу найргийн өмнөх гурван бадагт:

“Хэнтий, хангай, саяны өндөр сайхан нуруунууд
Хойт зүгийн чимэг болсон ой хөвч уулууд
Мэнэн, шарга, номины өргөн их говиуд
Өмнө зүгийн манлай болсон элсэн манхан далайнууд
Энэ бол миний төрсөн нутаг
Монголын сайхан орон
Хэрлэн, Онон, Туулын тунгалаг ариун мөрнүүд
Хотол олны эм болсон горхи булаг рашаанууд
Хөвсгөл, Увс, Буйрын гүн цэнхэр нуурууд
Хүмүүн малын умдаа болсон тойром бүрд уснууд
Энэ бол миний төрсөн нутаг
Монголын сайхан орон
Орхон, Сэлэнгэ, Хөхийн онц сайхан голууд

Уурхай баялгийн охь болсон уул, даваанууд
Хуучин хөшөө дурсгал, хот балгадын сууриуд
Холхи газар одсон харгуй дардан замууд
Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон” (D.Naᠰaᠭgdorji-yin büren jokiyaᠯ, 2016:93-94)

гэж монгол улсын нутаг дэвсгэр дэх уул нуруу, ой хөвч, говь элс, гол мөрөн, булаг рашаан, нуур бүрд, хөшөө дурсгал, хот балгад, харгуй зам зэргийг угсруулан дурдаж шүлэглэсэн байна. Хуурчаас дараагийн дөрвөн бадагт мөн Монгол орны уул ус, хээр тал, бэлчээр нутаг, байц бэрх, овоо тахилга, хөрс шороо зэргийг хураангуйлан ярих аргаар угсруулан шүлэглэжээ. Жишээлбэл :

“Холхи газраас гялалзсан цаст өндөр хайрхнууд
Хөх тэнгэр цэлмийсэн хөдөө хээр цайдмууд
Холын бараа харагдсан ноён шовх сарьдгууд
Хүмүүний сэтгэл тэнийсэн уудам амьсгалт талууд
Энэ бол миний төрсөн нутаг
Монголын сайхан орон
Хангай говийн хооронд халхын уудам нутаг
Хар бага наснаас хөндлөн гулд давхисан газар
Гөрөөс араатан авласан урт урт шилүүд
Хөлөг морин уралдсан хөндий сайхан хоолойнууд
Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон” (D.Naᠰaᠭgdorji-yin büren jokiyaᠯ, 2016:94)

хэмээн угсруулан шүлэглэв. Наймдугаар бадгаас арван нэгдүгээр бадгийн хорин хоёр мөрийн эцэст тус бүр “орон, нутаг, газар”-г оруулан холбож, монгол хүмүүн бүхний сэтгэлгээний ойлголтыг үүсгэж, шүлгийн сэтгэлгээг оргилд нь хүргэв. Жишээлбэл: Наймдугаар бадагт:

“Өлгий сайхан ууланд өвгөдийг тавьсан газар
Үр ач хүүхдийн үржиж өссөн орон
Монгол хүмүүн бидний сэтгэлийг сорсон нутаг
Манай янаглал амраглалд хөгжил болсон орон
Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон” (D.Naᠰaᠭgdorji-yin büren jokiyaᠯ, 2016:95)

хэмээн нэг бадгийн зургаан мөр, үгийн мөр бүрийн сүүлд “орон”, “нутаг” буюу “газар” зэрэг зангилаагийн үгийг холбож, шүлгийн санаа сэтгэлгээгээ ихэд лавшруулсан байдаг. Тус яруу найргийн хамгийн сүүлийн бадагт түүний гол утга санаа нь товойн илэрсэн юм. Түүнд:

“Өссөн төрсөн бидний үндсэн хайртай нутаг
Өнгөлзөгч дайсан ирвээс үтэр өшиглөн хөөнө
Хувьтай энэ орондоо хувьсгалт улсаа мандуулж
Хойчийн шинэ ертөнц дээр хүндтэй гавьяаг байгуулья
Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон ” (D.Naᠰaᠭgdorji-yin büren jokiyaᠯ, 2016:96-97)

хэмээн “өнгөлзөгч дайсан ирвэл үтэр өшиглөн хөөх” зориг санаа ба “хувьсгалт улсаа мандуулж, хүндтэй гавьяаг байгуулах” эрч зоригоо илтгэж, аман тангаргаа өгсөн байдаг. Энэхүү аман тангараг буюу уриалгийн бичгээр төгсгөсөн шүлэг нь “Би биш” хэмээх жүжгийн

зохиолын гол санааг хурц тод илрүүлж чадсан тул, хуурч гуай ч хуураа хурааж, уран найргаа өндөрлүүлсэн нь гайхалтай сайхан болжээ. Дээр өгүүлснээс гадна, тус жүжгийн зохиолд хуурч соном нь бас бүхий л жүжгийн зохиолын үйл явдлыг холбон хэлхэх үйлдэл үзүүлснээр барахгүй, жүжгийн зохиолын дүрүүдийг холбох, өөрөөр хэлбэл, хуурч нь гамин ноёнттой харилцах, гэрийн эзэн Цэрэнжавтай харилцах, Цэрэнжавын эхнэр Ханд ба Цэрэнжавын охин Дэнсмаатай харилцах жич Цэрэнжавын охин хүргэн Чулуунтай харилцахад бүр хүнд чухал үүргийг гүйцэтгэсэн билээ. Эдгээрийг энд дэлгэрүүлэн ярихыг зогсёе.

Гурав. Товч дүгнэлт

Дээр ярьсныг хураангуйлбал Монголын орчин үеийн утга зохиолын үндэслэгчийн нэг Д.Нацагдорж хийгээд Д.Намдагийнбичсэн жүжгийн зохиол “Би биш” дэх хуурч Соном бол тус зохиолын таван яруу найргийг хуурдан дуулж, холбон уянгалах чухал үүргийг гүйцэтгэсэн уран дүр болох юм. Зохиогчоор тус жүжгийн зохиолын нэг, хоёрдугаар дуунд хуурчийн амыг зээлж, Монгол оронд түрэмгийлэн ирсэн гамингийн цэрэг ноёны ял нүглийг шүүмжлэн дайрч, тэдний үхэл мөхлийг зүхэн хараасны дагуу Монгол орноо гамингуудад худалдсан “Шар хүрэмтэн, хармагнагтан, шашны дайсан, төрийн хулгайч” нарыг ч хүчтэй шүүмжлэн буруушаав. Гэхдээ гамингийн ял нүглийг голдуу Монгол оронд түрэмгийлэн ирж, Монгол орныг эзэлснээр үл барам Монголын сайхан хүүхэн Дэнсмаад халдсанаар бодитой үзүүлж, урлагаар бичин гаргажээ. Чулууны цэрэгт мордсон нь зөвхөн янаг хонгор Дэнсмаагийнхаа төлөө биш, харин Монгол орны үе түмэн залуучуудын чөлөөт янаг дурлалыг бусниулахгүйн төлөө эх орныхоо энх амгалангийн төлөө юм. Хуурчийн дуулсан гуравдугаар дуунд Чулуун хийгээд Дэнсмаа хоёрын чөлөөт янаг дурлалыг уянгалан дуулахдаа голдуу Дэнсмаагийн цэрэгт мордсон Чулуунаа энсэртэл санасан гүн гүнзгий хайр сэтгэлгээг илрүүлжээ. Зохиогч үүнээр дамжуулж, уншигч сонирхогчдын Дэнсмааг өр өвдөн хайрлах ба харгис гаминг улам илүү хорсон зангах зориг цөсийг хөвчилж чадсан байна. Хуурчийн дуулсан дөрөвдүгээр дуу нь гамин ноёны сахлыг хяргаж, гээг үс ба хувцас дээлийг нь солиод шуудайнд хийгээд байсан үед дуулагджээ. Хуурч гуай шуудайн дотор байгаа гамин ноёны дээр нь сандайлан суугаад, түүний Монгол нутагт түрэмгийлэн ирээд хийсэн ял гэмийг нэгд нэгээр тоочин шүүмжилж, түүний үхэл, мөхлийг зүхэн харааж өгвөөс зохих шийтгэлийг олгож, өргөн олон үзэгч сонирхогчдын дур бахыг хангаж чадсан юм. Нэн ялангуяа хуурчийн холбон дуулсан тавдугаар дуунд зохиогчийн тус жүжгийн зохиолд хэлье гэсэн гол утга санаа нь агуулагдсан байна. Зохиогчоор чээж дүүрэн халуун сэтгэлгээгээр Монгол орныхоо гайхамшигт сайхан уул тал, ус мөрөн, түүх дурсгал зэрэг ой төрхийг зах дараалан тоочин уянгалж, Монгол нутагтаа хэмжээлшгүй хайр сэтгэлгэтэй байгаагаа илтгэн, хамгийн сүүлд нь ийм сайхан нутагт өнгөлзөгч дайсан ирвэл үтэр өшиглөн хөөх зориг санаагаа илтгэж, энэ сайхан нутагтаа хувьсгалт тугаа мандуулж, хойчийн шинэ ертөнц дээр хүндтэй гавьяа байгуулахыг бүх ард түмэндээ уриалан дууджээ. Гэхдээ зохиогч энэ бүхнийгээ хуурчийн амаар хэлүүлснээс зохиолын ам сээр нь эвтэй сайхан нийлж, утга санаа нь аятайхан сайхан илэрч, бүх зохиолын гол санаа нь улам тод, улам хурц болж чадсан юм. Дахивал: тус жүжгийн зохиолд хуурчийн дүр нь бас бүхийл жүжгийн зохиолын үйл явдлыг холбон хэлхэх үйлдлийг үзүүлснээр барахгүй, жүжгийн зохиолын дүрүүдийг холбох үйлдэл, даруй хуурч гамин ноёнттой харьцах, гэрийн эзэн Цэрэнжавтай харилцах, Цэрэнжавын эхнэр Ханд ба Цэрэнжавын охин Дэнсмаатай харилцах жич Цэрэнжавын охин хүргэн Чулуунтай харилцахад бүр чухал үүргийг гүйцэтгэсэн юм. Тиймээс Д.Нацагдорж хийгээд Д.Намдагийн “Би биш” гэх жүжгийн зохиолд хуурч Соном нь бусад дүрүүдэд орлуулж эс чадах чухал дүр болж дурайн боссон юм.

Номзүй

D.Načaygdorji-yin büren jokiyal. Yu.Temürjin erkilen nayırayulba. Alus-un bar-a keblel-ün qoriy-a. Kökeqota. [Д.Нацагдоржийн бүрэн зохиол. Дэд боть. Ю.Төмөржин эрхлэн найруулав. Алсын бараа хэвлэлийн хороо. Хөххот], 2016.

Цогту. *Qayur-un üliger-ün sudulul.* Ündüsüten-ü keblel-ün qoriy-a. Begejing [Цогт. Хуурын үлгэрийн судлал. Үндэстний хэвлэлийн хороо. Бээжин], 2012.

Abstract

A Study of the Function of the Character Huurchi Sonom in the Play

Bi Bish (Not Me) by D. Nachugdorji and D. Namtug

Key words: D. Nachugdorji; D. Namtug; *Bi Bish (Not Me)*; function of the character Huurchi Sonom

Abstract: The present paper studies the function of the character of Huurchi Sonom in the play *Bi Bish (Not Me)* written by D. Nachugdorji and D. Namtug, through analyzing the relation of the five songs he sang with the theme, ideology and other characters of the play, and concludes that the character accomplishes several functions such as presenting the five songs closely related to the main theme of the play, communicating with other characters, and expressing the main ideology of patriotism and the criticism toward Guomindang's wrongdoings.